ХЭҮК

# МОНГОЛ УЛС ДАХЬ УУЛ УУРХАЙН БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ

# MINING AND HUMAN RIGHTS IN MONGOLIA



БАРИМТАТ МЭДЭЭЛЭЛ

FACT SHEET

# ОРЧНЫ БОХИРДОЛ, БАЙГАЛИЙН ТЭНЦЭЛ АЛДАГДАХААС ХАМГААЛУУЛАХ ЭРХ

**Уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин доройтож, байгалийн тэнцэл, түүний унаган төрх алдагдаж байна.**



***Уул уурхайн бүс нутгуудад агаарын бохирдол, усны хомсдол, хөрсний доройтол хэт их байгаа нь байгальд үлэмж хэмжээний хохирол учруулж байна.***

- Байгаль орчинд учруулсан нийт хохирол улсын хэмжээнд 1.16 их наяд төгрөг, хуулиар хориглосон бүсэд ногдох хохирол 672012.1 сая төгрөг байна. Үүнийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр авч үзвэл агаар мандалд 1963.0 сая төгрөг, гадаргын усанд 839627.4 сая төгрөг, газрын доорх усанд 30554.6 сая төгрөг, хөрсөн бүрхэвчинд 104433.5 сая төгрөг, ургамлан нөмрөгт 98204.5 сая төгрөг, эдэлбэр газарт 1660.8 сая төгрөг, газрын хэвлийд 67007.3 сая төгрөг, ойн санд 12816.7 сая төгрөг, ан амьтанд 3286.1 сая төгрөгийн хохирол учруулсан байна.

*(“Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлэх төрийн бодлого, ололт амжилт, бэрхшээл” илтгэлээс 2012 он)*

- 2012 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг (Цагаан хад) дах гаалийн хяналтын талбайн орчны агаарт хийсэн хэмжилтээр том ширхэглэлт тоосны дундаж агууламж “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2007 стандартад заасан хүлцэх хэмжээнээс 45 дахин их, нарийн ширхэглэлт тоосонцор 34-35 дахин их байна.

*(Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2012 оны 4/2056 дугаар албан бичиг)*

***Уул уурхайн замбараагүй тээвэрлэлтийн улмаас олон салаа зам үүсч, шороо тоос дэгдэж, газрын хөрс эвдэрч, бэлчээр талхлагдснаар хүн, амьтан дайжихад хүрч байна.***

- Говийн бүсэд буюу Дундговь аймгийн 7 сум, Дорноговь аймгийн 9 сумын нутаг тус бүрт 30-150 метр өргөнтэй 15-32 салаа зам үүсчээ. Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас хилийн Гашуун Сухайт боомт хүртэл 245 км хатуу хучилттай зам тавьсан болович ихэнх компаниуд гэрээ хийгээгүй, замын төлбөр өндөр гэх шалтгаанаар шороон замаар нүүрсээ тээвэрлэсээр байна.

*(Дундговь аймгийн Засаг даргын 2011 он 1/1088 дугаар албан бичиг)*

- Таван толгойгоос Цагаан хад хүртэлх 235 километр урт замын хоёр талаар нийт 35 250 га газрын хөрс эвдэрчээ.

*(Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Таван толгой-Гашуун Сухайт чиглэлийн замын хохирол тооцох ажлын тайлан”, 2011 он)*

***Уул уурхайн бүс нутгуудад усны нөөц багасч, булаг, шанд ширгэж ундны усны чанар, аюулгүй байдал алдагдаж байна.***

- Өмнөговь аймгийн Шивээ Хүрэн, Хэрмийн Цав, Дэрэнгийн Ус, Хадан Ус зэрэг газарт хийгдсэн усны чанарын судалгаагаар ундны усан дахь никелийн хэмжээ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын зөвлөсөн хязгаараас 2.5-5 дахин, кадмын хэмжээ 3 дахин өндөр агуулгатай илэрсэн байна.

*(Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, “Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумын... судалгааны ажлын тайлан”. 2010 он)*

- Жолооч нар бензин хийдэг хувингаараа худгийн уснаас хутгаж, уухын аргагүй үнэртэй болгодог. Өөр худаг байхгүй учир аргагүй эрхэнд л ууж байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн. Гурвантэс сумын малчин Ц-тэй хийсэн ярилцлага, 2012 он)*

# ОРЧНЫ БОХИРДОЛ, БАЙГАЛИЙН ТЭНЦЭЛ АЛДАГДАХААС ХАМГААЛУУЛАХ ЭРХ

***Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг тусгай хамгаалалттай болон бэлчээр, ус сайтай байгалийн тогтоц бүхий газруудад олгосон нь ялангуяа говийн эмзэг экосистемийг доройтуулж, нөхөн сэргээгдэхгүй байдалд хүргэхээр байна.***

- Геологи, уул уурхайн кадастрын зураглүйн болон мэдээллийн санд улсын тусгай хамгаалалттай 26,9 сая гектар талбай бүхий 106 газар бүртгэлтэй байгаагаас 19-д нь буюу 73.892 га талбайд тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

*(Ашигт малтмалын газрын 2012 оны 6-5999 дугаар албан бичиг)*

- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын хэмжээнд нийт 11 аж ахуйн нэгж ашиглалтын 16 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдээс гурав нь л үйл ажиллагаагаа явуулж байна. Үлдсэн аж ахуйн нэгжүүд бүгд олборлолтын ажлаа эхэлбэл манай суманд бэлчээр, гол, ус, тойром бүрдийн асуудал хүндэрч, зарим баг бүхэлдээ уурхайн талбай болох аюултай. Иймд тойром бүрд, бэлчээрийг хамарсан ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар төрөөс зохицуулах шаардлагатай байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Гурвантэс сумын удирдлагуудтай хийсэн ярилцлага, 2012 он)*

***Уул уурхайн зарим компаниуд нөхөн сэргээлт хийхгүй, хийсэн ч стандартын шаардлагыг хангадаггүйгээс байгалийн унаган төрх алдагдаж, газар нутгаа өмнө нь ашиглаж байсан зориулалтаар нь эргэн ашиглах боломжгүй байна.***

- Өвөрхангай аймгийн Уянга суманд 562.6 га, Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд 500 орчим га бэлчээр нутагт нөхөн сэргээлт хийлгүй орхигджээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн. 2012 он)*

- Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд байгаль орчинд нөхөн сэргээлт хийж байгаа эсэхийг малчдаас тандахад 34 хувь нь огт хийдэггүй, 40 хувь нь хагас дутуу, 12 хувь нь хийдэг, 14 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс, "Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө" судалгаа, 2012 он)*



# ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

**Хүн бүр хүний зэрэгтэй аз жаргалтай амьдрах, бусад эрх, эрх чөлөөгөө эдлэхэд зайлшгүй шаардлагатай эрх бол “эрүүл мэндээ хамгаалуулах эрх” юм.**



***Уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаа нь хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.***

- Өмнөговь аймагт хүн амын өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгааны нэгдүгээрт нь амьсгалын тогтолцооны өвчин байгаа бөгөөд 2007 онд 10000 хүн ам тутамд 1148.5 өвчлөлт бүртгэгдсэн нь 2009 онд 2188,8 болж даруй хоёр дахин өсчээ. Энэ үзүүлэлтийг улсын хэмжээний нийт ийм төрлийн өвчлөлтэй харьцуулахад 3.5 дахин их байна.

*( Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин хүний хөгжил, 2011 он)*

- Өмнөговь аймгийн Цогтцэций суманд амьсгалын тогтолцооны өвчин нэг жилийн дотор 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгаа, 2012 он)*

- Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар Чандмань суманд үзлэг хийхэд 71 хүний 68 нь нүдний өвчлөлтэй байсан ба энэ нь агаарын тоосжилт, хуурайшилт, бохирдолттой шууд холбоотой байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, 2012 он)*

- Дундговь аймгийн Баянжаргалан сум дахь жоншны уурхайнуудад ажилтнууд нь гар аргаар жонш олборлодог бөгөөд 2010 оны 5 дугаар сард аймгийн Эрүүл мэндийн газраас нарийн мэргэжлийн эмч нарын баг Баянжаргалан, Говь-Угтаал сумын 700 хүнд үзлэг хийхэд 20 орчим хувь буюу 140 гаруй хүний элэг шохойжилттой гэсэн онош тогтоогджээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, сумын удирдлагуудтай хийсэн ярилцлага, 2012 он)*






# ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

***Уул уурхайн бүс нутагт хүн амын тоо нэмэгдсэн ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт, хүртээмж хангалтгүй байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.***

- Манай эмнэлэг Цогтцэций сумын 4047 хүн ам, явуулын 8200 хүнд үйлчилж байна. Хүн амын тоо ихэссэн ч орон тоо нэмэгдээгүй, төсөв мөнгө хангалтгүй байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Цогтцэций сумын эмч нартай хийсэн ярилцлага, 2012 он)*

***Уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг хангалтгүй мөрдөж байгаа нь ажилтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.***

- Шөнийн цагаар орчны гэрэлтүүлэггүй, цахилгааны холболт нь ил задгай, тоног төхөөрөмж нь хаалт хамгаалалтгүй, хүнд нөхцөлд илүү цагаар ажиллуулснаар ажилтан ядаргаанд орох, болгоомж, сэрэмжээ алдахад хүрдэг байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө”судалгаа, 2012 он)*

- “...Олон өдөр, шөнө дараалан ажиллаж, нойргүйдсэний улмаас ажлын байрандаа анхаарал болгоомж алдаж өрөөсөн гараа хүнд машины араанд зажлуулж гаргүй болсон, мөн сэтгэцийн өөрчлөлттэй болсон тохиолдлууд ч байна”.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Цээл сумын эмч нартай хийсэн ярилцлага, 2012 он)*

***Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүсэд нутаглаж байгаа иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллага нь цаг алдалгүй хийх нь нэн тулгамдсан асуудал болжээ.***

- Малын ноосонд нүүрс, шороо шигсэн, хүнс бэлтгэхэд уушиг нь тас хар болсон байдаг. Тэгэхээр бид ямар байгаа бол...

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Цогтцэций сум, Сийрст багийн малчин Д-тэй хийсэн ярилцлага, 2012 он)*

# СОЁЛЫН ЭРХ

**Нүүдлийн мал аж ахуй нь монголчууд бидний олон мянган жилийн түүхтэй амьдралын хэв маяг, зан заншил, соёл, уламжлалын салшгүй хэсэг юм.**




***Нүүдлийн соёл, уламжлалт мал аж ахуй уул уурхайн хөгжилд шахагдаж байна.***

- 2004 оны байдлаар Цогтцэций, Ханбогд, Гурвантэс суманд нийт 3029 малчин байсан бол 2011 онд 1352 болж малчдын тоо 56 хувиар цөөрсөн байна.

*(Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс, Нийгэм, эдийн засгийн динамик үзүүлэлтүүд, 2012 он )*

- Судалгаанд оролцогч малчдын 60 хувь нь нүүх нутаг бэлчээргүй болж жилдээ 10-12 удаа отор, нүүдэл хийдэг байсан бол одоо 1-2 удаа нүүвэл ихэд тооцогдох болжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, 2012 он)*

***Малчид аргагүйн эрхэнд өсөж торнисон, идээшиж дассан газар нутгаа орхин нүүж өөр орон нутагт дасан зохицохын төлөө тэмцэж байна.***

- Судалгаанд оролцогч малчдын нутгаа орхин нүүж буй үндсэн шалтгаан нь бэлчээр хомсдсон, ундны болон мал уух усгүй болсон, тоос түйрэнд нэрвэгдсэнээс гэж хариулжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс "Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө"судалгаа, 2012 он)*

***Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим компанийн зүгээс нутгийн иргэдийн шашин шүтлэг, итгэл үнэмшилийг үл хүндэтгэх явдал гарч байна.***

- Хайгуулынхан тахилгатай уул хадыг тэгшилж овоон дээр машинтай явдаг. Нэг л сэрэхэд гэрийн хаяанд өрөмдөөд эхэлдэг. Хэлэхээр "Та нар дуугүй бай, бэлчээр нийтийн өмч, дээрээс зөвшөөрсөн" гээд тамгатай бичиг үзүүлдэг. Монголын газар нутаг дарга нарын тамгатай бичгээр зүйл дуусч байна даа.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Ханбогд сумын малчин Л-тэй хийсэн ярилцлага, 2012 он.)*

# СОЁЛЫН ЭРХ

***Уул уурхайн үйл ажиллагааны бүхий л шатанд тухайн орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, оролцуулах байдал хангалтгүй байна. Малчдын үе дамжин эзэмшиж ирсэн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохдоо нийт малчидтай зөвшилцөөгүйгээс тэдний эрх ашиг ноцтой зөрчигдөж байна.***

- “Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход нутгийн иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ” гэсэн хуулийн заалт байдаг ч судалгаанд оролцогч 50 малчдын 44 хувь нь энэхүү заалт огт хэрэгждэггүй, 48 хувь нь ийм заалт байдгийг ч мэдэхгүй гэж хариулжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө”судалгаа, 2012 он)*

- Гурвантэс, Ханбогд, Цогтцэций суманд л гэхэд өвөлжөөний газраа 60 жилийн хугацаагаар эзэмших гэрээ байгуулсан 46 малчны дийлэнх нь буюу 65 хувь нь албан ёсоор эзэмшиж буй газраа уул уурхайн компаний эдэлбэр газарт алджээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгаа, 2012 он)*

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тэдэнтэй зөвшилцдөг эсэхийг тодруулахад уул уурхайн бүсийн малчдын 94 хувь нь “үгүй” гэж хариулжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө”судалгаа, 2012 он)*

***Уул уурхай хөгжиж буй бүс нутгийн иргэд уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байна.***

- Гурвантэс, Ханбогд, Цогтцэций суманд нутаглаж буй судалгаанд оролцогч 50 малчдаас “Уул уурхайгаас хожсон уу, алдсан уу?” гэж асуухад 74 хувь нь “Алдсан нь их” гэжээ.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө”судалгаа, 2012 он)*

***Уул уурхайн үйл ажиллагаанаас эрх ашиг нь хөндөгдсөн малчдад учирсан эдийн болон эдийн бус хохирлыг тооцох аргачлал, стандарт байхгүйгээс хохирлоо бүрэн дүүрэн барагдуулж чадахгүй, сэтгэл ханамжгүй хоцорч байна .***

- Уул уурхайн компани болон малчдын хооронд малын бэлчээр, өвөлжөөгүй болсон талаар маргаан үүссэн. Хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр нийт 17 айлын өвөлжөө тухайн компанийн хайгуулын болон ашиглалтын талбайд орж улмаар мал аж ахуйгаа хэвийн үргэлжүүлэх боломжгүй болсон нь тогтоогдсон.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн. Бигэр сумын удирдлагуудтай хийсэн ярилцлага, 2012 он)*

# ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

**“Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлдэг дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ төлөө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ”**

***Хүрээлэн буй орчны тухай Стокгольмын тунхагийн 1 дүгээр суурь зарчмаас***



***Уул уурхайн үйлдвэрлэлд хэрэглэж буй хорт бодисыг хүн, малын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр ашиглах, хадгалах, устгах, тээвэрлэх явдал хангалтгүй байна.***

- 10 аймгийн нутаг дэвсгэрт хийсэн үзлэгээр алт олборлолтын нөлөөгөөр 120 гаруй цэгт мөнгөн ус, цианидаар бохирдсон 200,000 орчим тонн хаягдал, шлам үүсч, 53 га талбай, олон арван худаг бохирдсоныг тогтоожээ.

*(Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Монгол Улсын Байгаль орчны төлөв байдлын тайлан 2008-2010 он”)*

***Уул уурхайн бүс нутгуудад уурхайн олборлолт, тээвэрлэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, осол их гарч байна.***

- 2010-2012 оны 10 сарын байдлаар Өмнөговь аймагт нүүрсний зам дээр 310 зам тээврийн осол гарснаас 26 хүн нас барж, 44 хүн хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл авсан байна.

*(Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн мэдээлэл, 2012 он)*

- Цогтцэций суманд нүүрсний зам дээрх болон уул уурхайн үйлдвэрлэлийн ослын тоо зөвхөн нэг жилийн дотор 5 дахин нэмэгдсэн байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комисс, “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгаа, 2012 он)*

# ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

***Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн нүх, цооног, карьер, тогтоол усанд хүн, мал унаж үхэх, гэмтэж бэртэх явдал гарсаар байна.***

- Уурхайгаас болж манайх гурван сайхан хүүгээ алдсан. Бага насны хоёр хүү маань уурхайн тогтоол усанд унаж, нэг нь уурхайн тавьсан хурд сааруулагч дээр осолдож нас барсан.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, Гурвантэс сумын малчинтай хийсэн ярилцлага, 2012 он)*

- 2003-2012 онд Дорноговь аймгийн Айраг суманд гар аргаар ашигт малтмал олборлох явцдаа 15 хүн амиа алдсан байна.

*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн, 2012 он)*

# БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

## ХҮНД ЭЭЛТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА.

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ТОДОРХОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙГААГ ҮНЭЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ ЦААШИД:**

- ХУУЛИЙГ ЧАНД МӨРДСӨН
- БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛСАН
- ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХӨХИҮЛСЭН
- ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН
- НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ АНХААРАЛ ХАНДУУЛСАН
- СОЁЛ, УЛАМЖЛАЛЫГ ХҮНДЭТГЭСЭН
- ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН
- ИРЭЭДҮЙД УЧРАХ ХОР УРШГИЙГ ТООЦОЖ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛСЭН
- ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОДЛОГО, СТРАТЕГИ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

# БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

## ХҮНД ЭЭЛТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА.

### УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ТОДОРХОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙГААГ ҮНЭЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ ЦААШИД:

- ХУУЛИЙГ ЧАНД МӨРДСӨН
- БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛСАН
- ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХӨХИҮЛСЭН
- ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН
- НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ АНХААРАЛ ХАНДУУЛСАН
- СОЁЛ, УЛАМЖЛАЛЫГ ХҮНДЭТГЭСЭН
- ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН
- ИРЭЭДҮЙД УЧРАХ ХОР УРШГИЙГ ТООЦОЖ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛСЭН
- ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОДЛОГО, СТРАТЕГИ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

# RIGHT TO BE PROTECTED AGAINST ENVIRONMENTAL POLLUTION AND ECOLOGICAL IMBALANCE

**Irresponsible mining operations result in environmental degradation, ecological imbalance, and loss of wild and pristine nature of environment.**



***Increase of air pollution, water shortage, and soil degradation in the active mining regions is inflicting huge damage on the environment.***

- Damage to the environment costs 1.16 billion MNT at national level out of which 672,012.1 million MNT damage was done to the legally prohibited areas. To estimate it by per component of the environment, damage to atmosphere costs 1.93 million MNT, to surface water 839,627,4 million MNT, to ground water 30,554.6 million MNT, to soil layer 104,433.5 million MNT, to flora 98,204.5 million MNT, to common tenure land 1,660.8 million MNT, to subsoil 67,007,3 million MNT, to forest reserve 12,816.7 million MNT, and to fauna 3,286.7 million MNT.

*(“Government policy towards development of environmentally friendly mining, achievements and challenges”, Presentation by the Minister of Environment and Green Development, 2012)*

- According to the air quality test conducted in the Tsagaan Khad customs inspection area in Khairkhan Bagh, Khanbogd Soum, Umnugovi Province in 2012, average volume of dust with large particles was found to be 45 times higher and dust with small particles 34-35 times higher than allowed by the “Air quality and general technical criteria” standard MNS 4585:2007.

*(Official letter No. 4/2056 by General Agency for Specialized Inspection, 2012)*

***Herders are forced to abandon their land taking their cattle away due to dust storms, soil deterioration, and pastoral degradation caused by chaotic transportation of mining products on multiple off-roads.***

- In the territory of seven soums of Dundgovi Province and nine soums of Dornogovi Province, 30-150 meter broad 15-32 line off-roads have been created. Even though 245 km asphalt road was paved between Tsogttetsii Soum and Gashuun Sukhait port, most coal transporter companies are still using off-roads saying that they haven’t made contracts to use the paved road or the road fee is too high.

*(Official letter No. 1/1088 by Governor of Dundgobi Province, 2011)*

- Soil of 35,250 hectare area on the both side of 235 km long road between Tavan Tolgoi and Tsagaan khad has deteriorated.

*(Tavan Tolgoi-Gashuun Sukhait, Road Damage Assessment Report, Ministry of Environment and Tourism, 2011)*

***Water resources in the mining regions have decreased as the springs and wells dried up, and the quality and safety of drinking water has been deteriorating.***

- According to the water quality test made in the places such as Shivee Khuren, Khermen Tsav, Derengiin Us, and Khadan Us, volumes of nickel and cadmium in the water are discovered to be as 2.5-5 times high and 3 times high as the limits respectively recommended by the World Health Organization.

*(Study Report “Conducted in Tsogttsetsii, Khanbogd, and Gurvantes Soum, Umnugovi Province”, State Central Veterinary Laboratory, 2010)*

- By taking water from the wells with the buckets they use for petrol, drivers make smell and taste of the water so nasty that it is impossible to drink. We are forced to drink it because there is no other water source.

*(Interview with Mr.Ts, a herder in Gurvantes Soum, NHRCM, 2012)*

# RIGHT TO BE PROTECTED AGAINST ENVIRONMENTAL POLLUTION AND ECOLOGICAL IMBALANCE

***Vulnerable gobi ecosystem is under risk of irreparable deterioration because of issuing mining licenses in protected areas and/or in gobi areas with rarely abundant pasture and water.***

- Mining licenses have been issued for mineral extraction in 19 land plots of 73,892 hectare area that is registered as national protection areas. There are 106 such protected areas of 26,9 million hectare registered in the database of geological cadastre and cartography.

*(Official Letter No 6-5999 by Mineral Authority of Mongolia, 2012)*

- In Gurvantes Soum, Umnugovi Province, 11 business entities possess 16 mineral extraction licenses. Currently, three of them are extracting minerals. Once the remaining companies start mining operations, pasture and surface water in the territory of our bagh is going to be extremely tough; what is more, some baghs are going to be in danger of becoming mining field as a whole. Therefore, it is necessary for the government to take measures to cancel the licenses issued to do mining in the areas with surface water, springs, and pasturelands.

*(Interview with the Governor and other authorities of Gurvantes Soum, NHRCM, 2012)*

***Mining sites lose their original structure and become impossible to be utilized for residence and pasture again because of the failure of mining companies to carry out land rehabilitation at all or to adequate degree as required by standards.***

- There are 562.6 hectare of land in Uyanga Soum, Uvurkhangai Province and 500 hectare of land in Bayan-Ovoo Soum, Bayankhongor Province left without any rehabilitation.

*(Report of Investigation, NHRCM, 2012)*

- In replying to a question whether the mining companies working in Khanbogd, Tsogttsetsii, and Gurvantes Soums carry out rehabilitation work, 34% of respondent herders said "No", 40% answered "incomplete", 12% answered "Yes," and 14% answered "I don't know."

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*



# THE RIGHT TO HEALTH

**The right to health is fundamental for everyone to live in dignity and exercise their rights and freedoms.**



***Irresponsible mining activities have negative health effects for human beings and animals.***

- Respiratory diseases lead the ten top rated illnesses among the population of Umnugovi Province. As registered in 2007, 1148.5 people out of every 10,000 population were diagnosed with respiratory diseases. This figure doubled in 2009 reaching 2188,8, which makes it 3.5 times higher than the national average.

*(Mongolian Human Development Report, 2011)*

- Respiratory diseases rose by 2.5 times within a year in Tsogtsetsii Soum, Umnugovi Province.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

- Medical examination conducted in Chandmani Soum, Govi-Altai Province shows that 68 locals out of 71 were diagnosed with eye complications caused by road dust, dryness and air pollution.

*(Report of Investigation, NHRCM, 2012)*

- Medical examination shows that 20 percent of 700 locals from Bayanjargalan and Govi-Ugtaal Soums, Dundgovi Province, were diagnosed with liver disorder which was seen as associated with artisanal spar mining in the area.

*(Interview with local authorities, NHRCM, 2012)*




**Sickness rate in population of Tsogttsetsii Soum, Umnugovi Province**




**Top rated sickness in population of Tsogttsetsii Soum, Umnugovi Province**

# THE RIGHT TO HEALTH

***Despite the population growth in active mining regions, funding for health services remain low affecting the quality and availability of health care.***

- In Tsogttsetsii Soum, we provide health care for the native population of 4047 and 8200 non-residents. Population of the soum has grown largely. However, no additional funding has been given.

*(Interview with health care providers in Tsogttsetsii Soum, NHRCM, 2012)*

***Poor labor safety and hygiene in mining activities puts health at risk.***

- Mining workers are exhausted due to overtime work for long hours that leads to losing alertness and caution of their usually unsafe working conditions such as with no lighting, open electric wires and insufficient protection from dangerous devices and equipment.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

- "...There are cases of workers who lost a hand in the teeth of cog-wheel or those who ended up suffering from psychosis because of working over days and nights in a row without proper rest."

*(Interview with health care providers in Tseel Soum, NHRCM, 2012)*

***It has become imperative for relevant state authorities to start carrying out health and social impacts assessment in active mining areas.***

- A lot of coal and dust has got stuck in cattle hair. Cattle lungs are found to be all black when we prepare meat. Probably so are humans …

*(Interview with herdsman D. from Siirst vh, Tsogttsetsii Soum, 2012)*

# CULTURAL RIGHTS

**Pastoral cattle-breeding is inseparable part of Mongolian lifestyle, tradition and culture with a history of thousands of years.**




***Nomadic culture and traditional pastoral cattle-breeding are being pushed away by the mining development.***

- As of 2004, there were 3029 herders in Tsogttsetsii, Khanbogd, and Gurvantes Soums in total. However, this number decreased to 1352 herders or by 56 percent as of 2011.

*(Statistical division of Umnugovi Province, Social and Economic Indicators, 2012)*

- 60 percent of herders involved in the survey informed that they used to move around for pasture 10-12 times a year regularly, but now they can move around as high as one or two times a year due to loss of pastureland.

*(Report of Investigation, NHRCM, 2012)*

***Herders are left with no choice but to leave their traditional lands and struggling to adapt to other places.***

- Herders involved in the survey answered that the main reason to leave their traditional land is due to loss of pastureland, shortage of drinking water and suffering from dust and pollution.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

***There have been cases of some mining companies disrespecting the local communities' customs and beliefs.***

- Mining exploration groups are bulldozing our worshipped mountains and hills. They drive over the sacred places. All of a sudden, they start to drill next to our homes. When we ask them not to drill, they say "It is none of your business, pastureland is public property and authority gave us a permission to do so..." and show a paper with a stamp. Mongolian pastureland is being severely destroyed by stamped papers of the authorities.

*(Interview with herder Mr. L of Khanbogd Soum, NHRCM, 2012)*

# CULTURAL RIGHTS

***There is a serious lack of information for and involvement of local communities at all levels of mining activities. Rights and interests of herders are being gravely violated due to the failure to consult with them collectively before issuing a mineral license in areas where their uvuljuu (winter camp), khavarjaa (spring camp), zuslan (summer camp), and namarjaa (autumn camp) are located.***

- Though the law provides for "Decision of issuing a mining license be based on participation of local communities", 44 percent of 50 herders involved in the survey said that this legal provision is not enforced, whereas 48 percent of them said that they did not even know about the existence of this provision.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

- For instance, most (65%) of 46 herders living in Gurvantes, Khanbogd, and Tsogttsetsii Soums lost their land to mining companies despite their official entitlement through land use certificate that legally allows them to use the winter camp for 60 years.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

- 94 percent of herders living in active mining regions involved in the survey answered "no" to the question "whether the authorities consult with the herders before issuing a mineral licence".

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

***Local communities living in active mining regions are not happy about activities of mining companies.***

- 74 percent of 50 herders living in Gurvantes, Khanbogd, and Tsogttsetsii Soums involved in the survey answered "We lose more than we benefit" when asked if they benefited or lost because of mining.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

***Herders affected by mining are left with no effective remedy, nor satisfied with chance compensation due to the lack of standards and methodology for estimating material and non-material damage.***

- There have been disputes between mining companies and herders regarding pastureland and land of winter camps. According to the conclusion of a joint working group, 17 herder households lost their winter camp land to mining companies and became unable to continue normal livelihood with cattle-breeding.

*(Interview with authorities of Biger Soum, NHRCM, 2012)*

# RIGHT TO HEALTHY AND SAFE ENVIRONMENT

**Man has the fundamental right to freedom, equality and adequate conditions of life, in an environment of a quality that permits a life of dignity and well-being, and he bears a solemn responsibility to protect and improve the environment for present and future generations.**

***Principle One, Declaration of the United Nations Conference on the Human Environment***



***Utilization, storage, transportation, and disposal of toxic substances used in mining industry are not safe enough as not to have negative effect to human health and the environment.***

- As a result of inspection carried out in the territory of ten provinces, it was concluded that 200,000 tonnes of wastes polluted by mercury and cyanides have been left in 120 places after gold mining activities.

*("Environmental report of Mongolia, for 2008-2010, Ministry of Environment and Tourism")*

***In the active mining regions, the rate of crimes and accidents related to mining activity and transportation is high.***

- 310 traffic accidents occurred on the coal transporting roads in Umnugovi Province in the period from January to 2010 to October 2012, leaving 26 people dead and 44 people injured.

*(Traffic Police Section, Police Department of Umnugobi Province, 2012)*

- The number of traffic accidents on the coal transporting off-roads and industrial accidents has increased by five times within a year in Tsogttsetsii Soum.

*("Mining Impacts on Human Rights" study report, NHRCM, 2012)*

# RIGHT TO HEALTHY AND SAFE ENVIRONMENT

***Deaths and serious injuries occur because humans and animals accidentally fall into the holes, quarries, pits, and ponds created by the mining operations.***

- Because of mining, we lost all three of our sons. Two small ones drowned in a mine-created water pond, and the elder one died in traffic accident when crashing on the speed reducer set by the mining company.

*(Interview with a herder in Gurvantes Soum, Report of Investigation, NHRCM, 2012)*

- 15 persons died in Airag Soum, Dornogovi Province between 2003 and 2012 while engaging in artisanal mining.

*(Report of Investigation, NHRCM, 2012)*

# POLICY RECOMMENDATION

## HUMAN-CONSIDERATE AND RESPONSIBLE MINING POLICY IS REQUIRED.

WHILE RECOGNIZING CERTAIN POSITIVE INPUT OF MINING TO THE ECONOMIC AND SOCIAL DEVELOPMENT OF THE COUNTRY, IT IS IMPERATIVE TO REFORM POLICIES, STRATEGIES AND ACTIVITIES BASED ON:

- RULE OF LAW
- ENVIRONMENT PROTECTION
- HUMAN DEVELOPMENT
- SAFETY
- CONSIDERATION OF MARGINALIZED GROUPS
- RESPECT FOR CULTURE AND TRADITION
- PUBLIC PARTICIPATION
- EVALUATION AND PREVENTION OF AFTER-EFFECTS
- TRANSPARENCY AND OPENNESS.

# POLICY RECOMMENDATION

## HUMAN-CONSIDERATE AND RESPONSIBLE MINING POLICY IS REQUIRED.

WHILE RECOGNIZING CERTAIN POSITIVE INPUT OF MINING TO THE ECONOMIC AND SOCIAL DEVELOPMENT OF THE COUNTRY, IT IS IMPERATIVE TO REFORM POLICIES, STRATEGIES AND ACTIVITIES BASED ON:

- RULE OF LAW
- ENVIRONMENT PROTECTION
- HUMAN DEVELOPMENT
- SAFETY
- CONSIDERATION OF MARGINALIZED GROUPS
- RESPECT FOR CULTURE AND TRADITION
- PUBLIC PARTICIPATION
- EVALUATION AND PREVENTION OF AFTER-EFFECTS
- TRANSPARENCY AND OPENNESS.